

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

№	Удирдах ажилтны хүлээсэн үүрэг	Биелэлт	Хувь
1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулан жилийн эцсийн байдлаар тайланг холбогдох хүснэгтээр хугацаанд нь тайлагнан хүргүүлж ажилласан.	100
2	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар, “Засгийн газраас авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавруудын хэрэгжилтийг сар бүрийн 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.	100
3	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим (мерит)-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай 2 сул орон тоог байгууллагын цахим хуудас www.bagachuudkhuns.ub.gov.mn -д болон фэйсбүүк хуудсанд нийтэлж хоол зүйч, жолоочийн үүрэгт ажилд сонгон шалгаруулж томилсон. Хүүхэд харах чөлөөтэй байсан эрүүл ахуйчийг ажилд нь буцаан томилсон. Тайлант хугацаанд сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд 9 дүгээр сарын 16-ны өдрийн Б/17 тоот тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан болно.	100

4	<p>Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;</p>	<p>2025 оны зорилтот түвшингээр 8.669.696.02 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 4,869,322.76 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөний биелэлт 57 хувьтай байна. Өмнөх оноос 3,5 хувиар өсөлттэй байна. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг захирлын тушаалын дагуу тооллогын комисс тоолж ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>2025 оны 12 сарын 03-ны өдрийн байдлаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2025 оны төсөвлөсөн бүх зардлуудыг хэмнэж ажилласан байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Цалингийн зардлыг 259,919.50 мянган төгрөгөөр • Гэрэл цахилгааны зардлыг 60,036.11 мянган төгрөгөөр • Бичиг хэргийн зардал 5,126.11 мянган төгрөг • Шатахууны зардал 9,505.14 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажиллалаа. • Албан томилолтын зардал гараагүй. • Шагнал урамшуулалын зардал 3,750.00 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажиллалаа. 	80
5	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 79 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан “Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ”, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-гээр хүлээсэн үүргийг хангаж ажиллах;</p>	<p>Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг Нийслэлийн өмчийн харилцааны газраар уламжилж 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 25/11 дугаар гэрээг батлуулж, гэрээний үүргийг ханган ажиллаж байна.</p>	100
6	<p>Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;</p>	<p>Тайлант хугацаанд шүүхийн аливаа маргаанд нийслэлийн Засаг даргыг төлөөлөн оролцоогүй болно.</p>	100
7	<p>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл,</p>	<p>Хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаар Улаанбаатар</p>	100

	хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;	хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажилласан ажил байхгүй болно.	
8	Шаардлагатай тохиолдолд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
9	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллалаа.	100
10	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх;	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Өмчийн харилцааны газарт 02 дугаар сарын 17-ны өдөр 2025 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлуулахаар саналыг хүргүүлсэн. 2025 оны зорилтот түвшин батлагдсанаар ажилчдын албан тушаалын цалинг 20 хувиар нэмж, хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу хоол, унааны мөнгийг өдрийн 24,000.00 төгрөг болгож ажиллалаа. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам” Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хүрээнд Дөрөвдүгээр эмнэлэгтэй 01 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилтан эрт илрүүлгийн 29 төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдаж нийт 8,750,000.00 төгрөгийг зарцуулсан. Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй 01 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулан 17 ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа хамруулахад нийт 1,550,000.00 төгрөг зарцуулсан. Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.14-т заасны дагуу Хөдөлмөрийн	100

		<p>хүндэт медалиар шагнуулсан 2 ажилтанд тус бүр 1,000,000.00 төгрөг, нийт 2,000,000.00 төгрөг, 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу хурим хийсэн 1 ажилтанд 1,000,000.00 төгрөг, 8.11.2-т заасны дагуу 1 ажилтан Отгонтэнгэр их сургуулийн эрх зүйн ангид 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн эрх зүйчээр суралцаж байгаа тул сургалтын төлбөрийн 30 хувь болох 1,155,000 төгрөг, 8.12-т заасны дагуу ар гэрийн гачигдал гарсан 5 ажилтан тус бүр 1,000,000 төгрөг, нийт 5,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Сар шинийн баярыг тохиолдуулан 4 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж 600,000 төгрөг, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилчдын 29 хүүхдэд гарын бэлэг өгч, нийт 1,740,000 төгрөг, ахмадын баярыг тохиолдуулан 4 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж 600,000.00 төгрөгийг зарцуулж ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 17 ажилтан хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Дотооддоо сургалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу 01 дүгээр сарын 23-наас 10 дугаар сарын 16-ны өдрийн хооронд нийт 10 сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан.</p>	
11	Алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах	<p>Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн Монгол, хэл бичгийн багш Н.Жанчивтай гэрээ байгуулан ажилчдын монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 2 сарын сургалт зохион байгуулж, сургалтын үр дүнд байгууллагын ажилчдын монгол бичгийн ур чадвар нэмэгдэн бичиг баримтыг монгол бичгээр боловсруулах, явуулах, Mongolian Baiti программ дээр шивж бичих, монгол бичиг ашиглах чадвар нэмэгдсэн. 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр "Асгат" ОНӨААТҮГ, "Хүнс хангамж" ӨНОААТҮГ, "Өсвөр-Үе хүнс" ОНӨААТҮГ-тай хамтран "Архивчдын хөгжил" сургалтын төвөөс "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт" сэдвээр архив,</p>	100

		албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулсан ба уг сургалтад 4 байгууллагын нийт 42 ажилтан 8 цагийн танхимын сургалтад хамрагдсан болно. Тайлант хугацаанд сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд 9 дүгээр сарын 16-ны өдрийн Б/17 тоот тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан болно.	
12	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	Хүнсний бүтээгдэхүүний чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл аюулгүй хүнсийг захиалгын дагуу Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 74 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 16 ерөнхий боловсролын сургуулиудад хурдан шуурхай, чирэгдэлгүй нийлүүлэн ажиллаж байна.	100
13	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үүрэг даалгаврын хүрээнд нийслэлийн Засаг даргын баталсан 04 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн Дотоод аудитын газраас 2024 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Шалгалтаар нийт 3 төрлийн зөвлөмж ирсэн бөгөөд зөвлөмжийг 100 хувь биелүүлэн хэрэгжилтийг 2025 оны 09 сарын 03-ны өдрийн 131 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан болно.	100
14	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах;	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүнсний хангамжийн чанар, хүнсний хангамжийн хүртээмж гэсэн 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
15	Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;	Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг боловсруулсан ажил байхгүй ба өөрийн байгууллагаас шалтгаалсан мэдээллийг тухай бүрт нь мэдээллэн ажиллаж байна.	100
16	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах	Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, стандартыг вэб, фэйсбүүкийн Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын	100

		албан ёсны цахим хуудсаар дамжуулж, мөн Нийслэлийн үйл ажиллагааг сурталчилан таниулж ажиллаж байна.	
17	Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиас 2 удаа сэтгэл ханамжийн судалгаа авахад нийт 40 албан хаагч хамрагдсан. Судалгааг нэгтгэн судалгаанд оролцогчдын санал хүсэлтийг хүлээн авч, бараа бүтээгдэхүүний төрлийг нэмж, түгээлтийн багийн ажилчдад "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар" 1 удаа, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн нярвуудад "Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичгийн тухай ойлголт", "Бараа бүтээгдэхүүний онцлог" гэсэн сэдэвтэй 2 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан.	100
18	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	2025 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуй нэгж хуулийн этгээдээс, ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал, хүсэлт байхгүй болно. Тайлант хугацаанд нийслэлийн өргөдөл гомдлын цахим epg.ulaanbaatar.mn программаар ирсэн 6 өргөдлийг хүлээн авч ажилд орох 2, ажил хавсран гүйцэтгэх 1, ажлаас чөлөөлөх 3, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100
19	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2025 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн удирдах ажилтны 22 удаагийн шуурхай зөвлөгөөнд оролцсон. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 11 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
20	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлэн ажиллалаа.	100
21	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван	Байгууллагын цахим хаяг Bagachuudhuns.ub.gov.mn -25, Shilen.gov.mn -77 үзүүлэлтийн дагуу нийт 102 мэдээ, мэдээлэл, Shilendans.gov.mn сайтад 2025 онд нийт 157 мэдээлэл нийтлэхээс 1-ээс 12 дугаар саруудад 140	100

	<p>өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;</p>	<p>мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үлдсэн 17 мэдээлэл хугацаа нь болоогүй ба үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 4,292,414.8 мянган төгрөгийн орлогыг, нийт 3,328,097.73 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан. Байгууллагын мэдээллийн самбарт санхүү, хүний нөөц, ажлын зар, дүрэм журам, сургалтын мэдээлэл, шинэ мэдээлэл, үйл явцыг тухай бүр нь оруулан ажиллаж байна. UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст нэвтрэх эрх байхгүй болно.</p>	
22	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 33 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудад хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлахад 23 багцад 16 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 10 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 23 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 6 аж ахуйн нэгж байгууллагын 13 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 20 багцад дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийхэд 7 багцад 5 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 13 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 7 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 3 аж ахуйн нэгж байгууллагын 5 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй,</p>	100

		<p>төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 15 багцад дахин нээлттэй тендер шалгаруулалтыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зарлаж, 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр нээлтэй хийхэд 3 багцад 2 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 12 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 3 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 2 аж ахуйн нэгж байгууллагын 3 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 12 багцад 09 дүгээр сарын 08-ны өдөр дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр нээлтээ хийхэд 8 багцад 2 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 4 багцад огт тендерийн материал ирээгүй бөгөөд 8 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 1 аж ахуйн нэгж байгууллагын 7 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, нэг ч оролцогч оролцоогүй 5 багц байна. Тендерийн баримт бичгийг хянан, тендер хүлээн авч байгаа ба ил тод байдал, чанар, хугацаа, олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналтыг сайжруулан, холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. Shilendans.gov.mn сайтад 2025 онд нийт 157 мэдээлэл нийтлэхээс 1-ээс 12 дугаар саруудад 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үлдсэн 17 мэдээлэл хугацаа нь болоогүй ба үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 4,292,414.8 мянган төгрөгийн орлогыг, нийт 3,328,097.73 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан.</p>	
23	<p>Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах;</p>	<p>Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулсан ажил байхгүй болно.</p>	

24	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээлэл болон нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстээс гаргаж буй мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь bagachuudkhuns.gov.mn сайт болон фэйсбүүкийн Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын албан ёсны цахим хуудсанд тавин олон нийтэд түгээн ажиллаж байна.	100
----	---	---	-----

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХНАСАН